

Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын
2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Сэдэв: “Шүүх шинжилгээний хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурал.

Зорилго: Монгол Улсад шүүх шинжилгээ хийж ирсэн ололт, амжилтыг тодорхойлж, хүний эрх, эрх чөлөөг хангахад шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг үр дүнтэй ашиглахад онол, арга зүй, техник зүй, эрх зүйн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замыг оновчтой тодорхойлохын тулд дотоод, гадаадын байгууллагын туршлагыг харьцуулан судалж, эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүн, байр суурийг нэгтгэн санал, зөвлөмж боловсруулахад эрдэм шинжилгээний хурлын зорилго чиглэгдэнэ.

Хамрах хүрээ: Монгол Улсын шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагууд, хамтын ажиллагаа бүхий дотоод, гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаач нар.

Ерөнхий зохион байгуулагч:

- Шүүх шинжилгээний ерөнхий газар

Хамтран зохион байгуулагч:

- Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлахуйн институт

Оролцогч байгууллага:

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба
- Шинжлэх ухааны академи
- УДШ-ийн дэргэдэх Сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн
- УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн
- Тагнуулын ерөнхий газар
- Цагдаагийн ерөнхий газар
- Хил хамгаалах ерөнхий газар
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- Онцгой байдлын ерөнхий газар
- Гаалийн ерөнхий газар
- Гадаадын иргэн харьяатын газар
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Хууль зүйн үндэсний хүрээлэн
- Монголын хуульчдын холбоо
- Монголын өмгөөлөгчдийн холбоо
- Монгол Улсын их сургууль
- Үндэсний тагнуулын академи
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

Хурал зохион байгуулах хэлбэр: Хурлыг танхимаар зохион байгуулна.

Хурал зохион байгуулах газар: Дотоод хэргийн их сургуулийн Соёлын төвд зохион байгуулна.

Хурал зохион байгуулах хугацаа: 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 09:00 цаг

Илтгэлийн сэдвийн үндсэн чиглэл:

- Шинжлэн магадлах ухааны онолын асуудал
- Шүүх шинжилгээний арга зүйн асуудал
- Шүүх шинжилгээний эрх зүйн асуудал
- Шинжлэн магадлах ухааны инновац
- Шинжлэн магадлах ухааны боловсрол судлалын асуудал
- Шүүх шинжилгээ хийх үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудал
- Шүүх шинжилгээ хийх үйл ажиллагааны аюулгүй байдал
- Шүүх ба шүүх шинжилгээ
- Прокурор ба шүүх шинжилгээ
- Мөрдөх алба ба шүүх шинжилгээ
- Гааль, хяналтын байгууллага ба шүүх шинжилгээ
- Хил хамгаалалт ба шүүх шинжилгээ
- Гамшиг судлал ба шүүх шинжилгээ
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл ба шүүх шинжилгээ

Илтгэлд тавигдах ерөнхий болон техникийн шаардлага:

а) Хэлбэрийн хувьд:

- Илтгэл нь сэдэв, илтгэгчийн овог, нэр, цахим шуудангийн хаяг, хураангуй, түлхүүр үг, (англи хэл, монгол хэлээр), оршил, судалгааны ажлын үр дүн буюу үндсэн хэсэг, дүгнэлт, санал, хавсралт, эх сурвалжийн жагсаалтаас бүрдэнэ.

б) Агуулгын хувьд:

- Сэдвийн үндсэн чиглэлийн хүрээнд бичсэн байх;

- Судалгааны ажил бодит баримт, судалгааны үр дүнд үндэслэсэн, тодорхой үр дүнд хүрсэн байх;

- Судалгааны шинэлэг тал, практик ач холбогдлыг тодорхойлох;

- Дэвшүүлсэн санал, дүгнэлт оновчтой, практикт нэвтрэх, хэрэгжих боломжтой байх;

в) Илтгэлд тавигдах техник шаардлага:

- Microsoft Office Word, үсгийн хэмжээ Times New Roman-12, бичвэрийн хэмжээ тал бүрээс 2.5 см, мөр хоорондын зайд 1.15, цаасны хэмжээ A4 формат байх;

- Илтгэл утга найруулга, хэл зүйн болон техникийн алдаагүй, 6-8 тал байх бөгөөд цаасны зөвхөн нэг тал дээр хэвлэсэн байх;

- Илтгэлд үзүүлэх материалыг хавсаргаж болно (дурс бичлэг, гэрэл зураг, схем гэх мэт).

- Илтгэлийг эрдэмтэн, судлаач дангаараа болон бусадтай хамтран бичиж болно.

- Илтгэлийн эхийг хэвлэмэл болон цахимаар хүлээн авна.

Хурлын хэл: Монгол

Илтгэл хүлээн авах хугацаа: Илтгэлийн эхийг хэвлэмэл болон цахимаар (science@nfa.gov.mn) 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 18:00 цаг хүртэл хүлээн авч, бүртгэнэ.

Холбоо барих, мэдээлэл авах утас, хаяг: 51-264024, 9811-4437, 9905-9271
цахим хаяг: science@nfa.gov.mn

Хурлын үр дүн: Ирүүлсэн илтгэлийн онол, практикийн ач холбогдлыг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, практик үйл ажиллагааны эргэлтэд оруулж, сэдэв, чиглэлийн дагуу зөвлөмж боловсруулна.

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР

